

Батсуурийн Анхбаяр^{1✉}, Жамъянгаравын Цамбагарав²

¹ ШУА-ийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 1 байр

² Хархорум музей
Монгол улс, Өвөрхангай аймаг, Хархорин сум,
Ганган-Орхон баг, Соёмбо хороолол

Өндөр улааны дурсгалын тухай дахин өгүүлэх нь

Хураангуй. Харьцангуй өргөн хүрээнд тархсан хүннүгийн булш оршуулгын залгамж холбооны асуудал ямагт анхаарал татсаар байгаа сэдэв юм. Иймээс Сяньби, Жужаны булш оршуулга хийгээд хожмын монголчуудын оршуулгын дурсгалын судалгаанд Өндөр улаан уулын өвөрт буй шороон дов, тэндээс илэрсэн булш чухал материал болсон юм. Уг дурсгалын малтлагын явц, булшнаас илэрсэн эд өлгийн зүйл хийгээд нас барагчийн яснаас авсан дээжийн он цаг тогтоох лабораторийн хариунд тулгуурлан өмнөх судалгааны үр дүнг бататган, тайлбарлах оролдлого хийлээ. Өндөр улааны шороон довыг Талын гурван хэрэмтэй харьцуулан Хүннү улсын үед бүтээгдсэн хэмээн үзэж байна. Харин ямар нэгэн шалтгаанаас дутуу орхиж хулирсны дараа оруулмал булшийг дээр нь үйлджээ. Булшийг IV зууны төгсгөлөөс V зууны эхэнд холбогдуулсан өмнөх судалгааг лабораторийн дээжийн хариуд (НТ381-425 он) тулгуурлан Жужан улсын үед холбогдохыг бататган тогтоолоо. Хүннү, Хангийн улс төрийн тэмцэлд өвөг дээдсийн онгон хүүрийг тонож доромжлох явдал гарсан нь асар их сургамж болсон тул оршуулгын хөрсний дээр ямар нэгэн тэмдэг тавилгүй нуух, агуй хад чулууны хөмөгт дарах, чандарлах зан үйл давамгайлж улмаар тал нутгийн овог аймгуудад уламжлагдсан гэсэн судлаачдын саналыг бататгах нэгэн баримт болно. Өндөр улааны дурсгалаас олдсон булш нь жужаны үеийг төлөөлөх цөөн дурсгалын нэг болсноор цаашид хүннүгийн дараах нүүдэлчдийн оршуулгын соёлыг судлахад үнэтэй хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй.

Түлхүүр үг: Шороон дов, Өндөр улааны булш, он цаг, Жужан

Batsuuri Ankhbayar^{1✉}, Jamiyangarav Tsambagarav²

¹ Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar 13330, Mongolia

² Kharakhorum museum,
Soyombo street, Gangan-Orkhon bag,
Kharkhorin soum, Uvurkhangai province, Mongolia

Revisiting the Öndör Ulaan Site

Abstract. The issue of the continuity of Xiongnu burial traditions, which were widely distributed across vast territories, has long been a subject of scholarly interest. Therefore, in the study of the burial customs of the Xianbei, Rouran, and later Mongols, the earthen mound located at the foot of Öndör Ulaan Mountain and the tomb discovered there have provided important materials.

Based on the excavation process, the artifacts unearthed from the tomb, and the laboratory results of radiocarbon dating of the human remains, this study attempts to reaffirm and further interpret the findings of previous research. The earthen mound at Öndör Ulaan is considered to have been constructed during the period of the Xiongnu Empire, in comparison with the “Three Fortresses of the Steppe.” However, after being abandoned for some reason, a secondary intrusive burial was later placed on top of it.

The earlier research that dated the tomb to the late 4th–early 5th century CE has been confirmed by laboratory analysis (381–425 CE), indicating that it belongs to the period of the Rouran Khaganate. Historical accounts mention that during the political conflicts between the Xiongnu and Han empires, the desecration and looting of ancestral tombs caused deep

moral and cultural trauma. As a result, burial practices shifted toward concealing graves without surface markers, interment in caves or rock shelters, and cremation—a tradition that was subsequently inherited by nomadic tribes across the steppe. The Öndör Ulaan tomb, as one of the few archaeological remains representing the Rouran period, provides valuable material for studying the funerary culture of post-Xiongnu nomads.

Keywords: *Earthen mound, Öndör Ulaan tomb, chronology, Rouran*

Удиртгал

2015 оны зун Архангай аймгийн Өгийнуур сумын нутаг Хэрмэн талын Талын гурван хэрмээс баруун зүгт нэгэн шороон дов мэт байгууламж байгааг судлаач Х.Цэрэнбямба олж үзсэнээр, дараа жил нь буюу 2016 оны 7-8 сард уг дурсгалд археологийн малтлага судалгаа хийсэн юм (Очир нар, 2016: 43-59). Шороон дов мэт уг дурсгалын тухай судлаач Т.Идэрхангай Цантын булангийн бунхан нэрээр эрдэм шинжилгээний эргэлтэд оруулж Түрэг, Уйгурын үед холбогдох бунхантай булш хэмээн таамагласан байдаг (Идэрхангай, 2015: 153). Уг дурсгал Тамир голын хойд эрэг дээр 4 км орчим зайд, Талын гурван хэрэм дурсгалаас баруун зүгт 4 км зайд Өгийнуур, Батцэнгэл сумдын зааг Өндөр улаан хэмээх уулын зүүн урд хавтгай дэвсгэр дээр оршино (Зураг 1, 2). Энэ дурсгалд малтлага судалгаа хийх явцад нэгэн булшийг илрүүлэн олж малтсан юм. Монгол, Хятадын хамтарсан судалгааны анги Өндөр улааны дурсгалаас холгүй орших Талын гурван хэрэмд 2014 онд судалгаа хийх явцад Баруун хэрмийн төвийн байгууламжаас зохион байгуулалт, олдвор хэрэглэгдэхүүний хувьд Өндөр улааны булштай тун төстэй булш илрүүлж он цаг тогтоох дээжийн хариуд үндэслэн Талын гурван хэрмийн жужаны үеийн булш хэмээх нэрээр нийтэлсэн (Очир нар, 2015: 380-404). Түүнчлэн Талын гурван хэрмийн булшны хүний ясанд ДНА-гийн харьцуулсан судалгаа хийснээр эртний Дунху–Сяньби угсааны салбар нь жужанчуудын эцгийн удамд генетикийн чухал хувь нэмэр оруулсан байх магадлалтай. Энэ удмын урсгал нь цаашлаад орчин үеийн монгол болон манж хэлтэн угсаатны генофонд руу орсон гэж үзжээ (Jiawei Li, 2018: 1-11). Өндөр улааны дурсгалыг малтахад оролцсон зарим судлаач уг булшны олдворт тулгуурлан харьцуулж IV сүүлч V зууны эхэн үед холбогдох боломжтой хэмээн таамагласан судалгаа Хятадын Нийгмийн шинжлэх ухааны академийн Археологи сэтгүүлд хэвлүүлжээ (程鹏飞, 2023: 47-52). Нэрт судлаач А.Очир монголчуудын угсаа гарлын талаарх нэгэн бүтээлд, Өндөр улааны булшны олдвор, дурсгалын зохион байгуулалтад дулдуйдан Жужан булш гэж нэрлээд хожмын монголчуудын оршуулгын ёс, оршуулгын соёлд мэдэгдэхүйц уламжилсан хэмээжээ (Очир, 2020:183).

Тухайн үед бид Өндөр улааны дурсгалын ойролцоох Талын гурван хэрэмд археологийн судалгаа хийж байсан тул орчмын дурсгалуудыг бүртгэх, харьцуулах, байр зүйн судалгаа зэргийг явуулж байлаа. Өндөр улааны дурсгалыг үзэж анхны баримтжуулалтыг үйлдэх үед гадаад зохион байгуулалтын хувьд Талын гурван хэрмээс ялгаатай болон ижилсэл байсан нь анхаарал татсан юм (Зураг 2). Тиймээс уг дурсгалыг судлах зайлшгүй шаардлагатай гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, Өндөр улааны дурсгал хийгээд Талын гурван хэрмийн дунд харилцаатай эсэх, нэг цаг үеийн дурсгал мөн үү гэдгийг тодруулах зорилгоор малтлага хийсэн билээ.

Өндөр улааны дурсгал зөвхөн шороон овоолгоос бүтсэн байгууламж бөгөөд гадуураа хэрэм, усны татаал байхгүй боловч түүний гадаад бүтэц, зохион байгуулалт Талын гурван хэрмийн байгууламжуудтай төстэй тул “Талын гурван хэрмийн дагуул байгууламж”, “бүрэлдэхүүн” нэг бол бүхий л шинжээрээ Түрэг, Уйгурын үеийн бунхантай булш гэсэн таамгуудад судалгааны багийн гишүүд санал хуваагдаж байлаа. Мөн 2014 онд Талын гурван хэрмээс илрүүлсэнтэй адил Жужан улсын үед холбогдох булш байх магадлалтай тул онцгой дурсгал нь ойлгомжтой байлаа. Ямар боловч Өндөр улааны дурсгалд малтлага хийж нягталснаар, зөвхөн Өндөр улааны дурсгалын үүрэг зориулалтыг тогтоохоос гадна Талын гурван хэрэм хийгээд Тамир голын савд буй цөөнгүй шороон овоолготой дов мэт байгууламжуудыг тодруулахад тустай байв.

Судалгааны арга зүй

Өндөр улааны дурсгалыг малтахаас өмнө бид Орхоны хөндийд орших Дөрвөлжингүүд, Баянцогтын дурсгал, Туул голын савд буй Заан хошууны дурсгал, Орхон голын савд буй Булгийн толгой зэрэг газарт шороон дов, бунхантай булш малтсан учир малтлагын арга зүйн хувьд үүдэвч хайж олох ёстойг ойлгож байв. Өөрөөр хэлбэл, шороон довын өмнө юм уу зүүн өмнө талд (Тамир голын чигт, газрын хэвгийг талыг барьсан, алсын бараа харсан, нарны тусгал зэргийг бодолцож) тодорхой зайнаас шороон овоолгыг чиглэсэн үүдэвчээр дамжин довын доор эрүүл газрыг хөндийлөн ухаж оршуулгын тасалгаа буюу

бунхныг үйлдсэн байдаг. Иймээс малтлагын доорх арга зүйн төлөвлөгөөг боловсруулж эхлүүлсэн.

- Үүдэвчийг хайж олох малтлага,
- Шороон довын бүтэц, үүрэг зориулалт, хэлбэр, хэмжээ, бүтээсэн шавар шорооны өнгө (энэ орчмын шороо юм уу, зориуд холоос авчирсан уу) зэргийг тодорхойлох сорилын сувгийн малтлага,
- Шороон байгууламж дээр оруулга булш байгаа эсэхийг шалгах талбайн малтлага

Байгууламжийн гадаад зохион байгуулалтын хувьд сууриараа баруун хойноос зүүн урагш 37 х 33 м орчим хэмжээ бүхий зууван дугуй хэлбэртэй, төв рүүгээ конус хэлбэртэй нарийсаж төвийсөн, дээрээ суурьтайгаа адил зууван хэлбэртэй боловч бага зэрэг хавтгай 1.15 х 2.30 см орчим хэмжээтэй, нийт 2.2 м өндөр аж. Дурсгалын анхны байдлыг баримтжуулсны дараа шороон байгууламжийн зүүн өмнө болон өмнө хэсэгт 2 х 10 м, 2.5 х 10 м хэмжээтэй 5 талбайд 35-50 см хүртэл гүн малтахад ямар нэгэн соёлт давхарга мэдэгдсэнгүй байгалийн хөрсөнд тулсан (Зураг 3, MD1-MD5).

Шороон довыг бүхэлд нь багтааж хойноос өмнө зүгт чиглэсэн 2 м өргөн, 43 м урт сорилын суваг малтав. Чингэхдээ шороон довын төвд 50 см өргөн зүсэлтийн далан үлдээж 2 хэсэгт хуваагаад (Зураг 3, TG1, TG2) байгалийн хөрс хүртэл цэвэрлэсэн.

Сорилын сувгийн баруун зүүн талд 4 х 4 м хэмжээтэй 6 талбай, 4 х 6 м хэмжээтэй 3 талбай, 4 х 7 м хэмжээтэй 2 талбайг нээж 30-215 см гүн малтав (Зураг 3, TG1-9).

Малтлага судалгааны үр дүн. Юуны өмнө малтлага судалгааны үр дүнд Өндөр улааны дурсгал нь бунхант булш биш болохыг тогтоов. Анхны байдал нь 2 метрээс дээш өндөртэй, 15 х 17 м хэмжээтэй өмнө зүгт 177 хэмд чиглэсэн дөрвөлжин хэлбэртэй шороон байгууламж ажээ. Уг шороон байгууламжийг дурсгалаас баруун урагш 50 м орчим зайд буй ухмалаас шороо авч үелүүлэн тарааж асгаад дэлдсэн байна (Зураг 9). Байгууламжийн хана 5-7 хэмийн налуу бүтээгдсэн боловч он жилийн уртад урсан тарж, нөмөрдөн шавсаар шороон дов болон хувирчээ. Мөн тарвага зэрэг мэрэгчид үүрлэснээр анхны зохион байгуулалт үндсэндээ мэдэгдэх төдий болжээ. Шороон байгууламжийн ханын гадуур ёроолдоо хавтгай чулуутай жижиг нүхнүүд олдсон нь (Зураг 10) тухайн байгууламжийг барихдаа ашигласан модон хашлаганы модон шонгуудыг бэхлэх үүрэгтэй ажээ. Харин ханаас гадагш урссан хөх саарал өнгийн шавар байсан нь байгууламжийн ханыг өнгөлсөн материал бололтой (Зураг 11).

Дурсгалд хийсэн талбайн малтлагаар оруулга булш илрээгүй боловч янз бүрийн бүтэц, хэмжээ, шатаалттай шавар савны 10 орчим жижиг

хагархай олдсон бол сорилын сувгийн малтлагаар байгууламжийн төв хэсэгт нэгэн булш байгааг илрүүлэв (Зураг 3). Шороон довын төвд хамгийн өндөрлөг хэсэгт 10 см орчим зузаан ургамлын бүрхэвч ялзмагжсан хөрсийг авсны дараа баруун хойноос зүүн урагш чиглэлтэй 220 см урт, 100 см орчим өргөн толбо мэдэгдэж байлаа. Уг толбо шороон байгууламжийг доош нь ухсан тул дагуулан цэвэрлэсээр байгалийн хөрс рүү шурган 20 см илүү үргэлжлээд нийт 240 см гүн болоход ихэд ялзарч муудсан боловч углуурга ашигласан 205 см урт, 70-60 см өргөн модон авсны үлдэгдэл илэрсэн. Тагны үлдэгдлийг аваад оршуулгыг цэвэрлэхэд нас барагчийг толгойгоор нь баруун хойш 290 хэмд чиглүүлээд дээш харуулж тэнэгэр байдлаар тавьсан хүний яс илэрлээ. Чингэхдээ нас барагчийн толгойг цэхлэн гарыг биеийн дагуу тавиад хөлийг жийлгэжээ (Зураг 4). Хүний ясны хадгалалт дунд зэрэг, мэрэгчийн нөлөөгөөр хөдөлж анхны байрлалаа бага зэрэг алдсан нь ажиглагддаг. Хүний ясанд хийсэн он цаг тогтоох лабораторийн судалгааг Япон улсын Токиогийн их сургуульд илгээж хийлгэхэд НТ381-425 онд холбогдож байна (Зураг 5).

Олдвор. Оршуулгаас 13 тооны эд өлгийн зүйл илэрлээ. Тэдгээрийг ясан эдлэл, төмөр эдлэл, хүрэл эдлэл, шавар сав, модон эдлэл хийгээд арьс ширэн эдлэл, бөс даавуун эдлэл хэмээн ангилж болно. Тэдгээрийн байрлалыг тодруулбал, хүний хүзүү, эрүүний орчмоос хүрэл зүүлт, цээжний баруун хэсэг хийгээд баруун гарын бугалгын орчмоос төмөр зэв, элэг хавирганы орчмоос нумын ясан наалт, цээжний зүүн тал бүсэлхий орчмоос хүрэл чимхүүр, баруун гарын шуу сарвууны орчмоос бөс даавуу, ширэн эдлэлийн тамтархай, хөлийн тавхай орчмоос шавар савны хагархай, нуруу тахим орчмоос модон авсны шал, хүний зүүн талаас модон авсны хашлага, хүний аарцгийн зүүн талаас бог малын ууц нурууны яс бүтнээрээ, сээрний ясны зарим хэсэг зэрэг байна. Олдворууд өмнө нийтлэгдсэн боловч үүрэг зориулалт хийгээд бусад мэдээллийг нэмж дэлгэрүүлсэн, засаж сайжруулсан, дутуу орхигдсон олдворыг нөхвөрлөсөн тул тодорхойлов.

Хүзүүний хүрэл зүүлт – Зориуд бэлдсэн хэвд цутгасан тал саран хэлбэртэй хүрэл зүүлт. Нас барагчийн хүзүүний орчмоос олдсон явдал нь хүзүүнээс зүүх зориулалттайг гэрчилдэг. Дунд хэсэгтээ өргөн, хоёр үзүүр лүү шувтан. Төв хэсгийн доор унжлага мэт гадагш түрсэн дугуй дүрслэл бий. Түүний хэлбэрийг дагуулан хөвөөлсөн төвгөр хээ нуман хэлбэртэй харагдуулна. Эдлэлийн гадаргуу тэгш толигор бөгөөд хөвөөлдөж эмжсэн жигд налуу бол дотор тал барсгар. Иймээс нэг талтай хэв ашиглажээ. Уг эдлэл 3 хэсэг болж хугарсан байдалтай олдсоны нэг талын үзүүр үрэгдсэн. Одоо

байгаа хэмжээ нь 18.3 см урт, 1.5-2.1 см өргөн, (голын унжлагатай хэсгээр 3.1 см өргөн) 0.1 см зузаан. Хүрэл зүүлтийн хамт 1 ш дугуй хэлбэртэй, 2 нүхтэй, хавтгай хүрэл эдлэл (голч 0.9 см, 0.8 см зузаан, нүхний голч 0.1 см), төвдөө нүхтэй дугуй сувс 1 ширхэг (0.8 х 0.5 см, нүхний голч 0.2 см) олдсон нь сүвлэж чимэглэх үүрэгтэй (Зураг 6-1).

Модон гал асаагуур – Модыг засаж хийсэн гал асаах үүрэгтэй эдлэл. Уртлаг зууван хэлбэртэй, хэвтээ талаар нь дөрвөлжлөн зассан. Хэмжээ 14 см урт, 2.9 өргөн, 2 см зузаан. Хэвтээ талын нэг хавтгай гадаргууд дунджаар 1.1 см голчтой, 0.9 см гүн 7 нүхийг цувуулж хонхор гаргасан. Нүх хэрэглээний явцад хагарч нийлжээ. Зууван талын нэг үзүүрт 1.1 см хэмжээтэй бүтэн тойрог ховилтой. Уг ховилоор гогцоолдож нарийн сураар оосорлон агсарга бүснээс зүүж явдаг зориулалттай аж (Зураг 6-6).

Суран бүстэй хүрэл агсаргын үлдэгдэл – Хүний баруун ташаа, бүсэлхий орчмоос илэрсэн. Сурыг өргөн талаас нь нугалж хэвшүүлээд нийлсэн амыг нь эмхэрдэж жигд оёсон бүсний тасархай. Хэмжээ нь 9.4 см урт, хүрэл агсарга суран бүсний 2 тасархай байна. Түүний урт хэсгийг тодорхойлбол, хүрэл бэлдцийг хавтгайлан цохиж нимгэлж хавчуулсан, гонзгой дөрвөлжин хэлбэртэй 6.3 см урт, гадна тал нь 2 см өргөн, дотор тал нь 1.2 см өргөн, 0.2 см зузаан. Урт талын хоёр үзүүрийг дугуйлж засаад, дундуур нь нугалж нуруутай талын хоёр захыг 0.4 х 0.4 см хэмжээтэй онилон засжээ. Ингээд 0.4 см голчтой хүрэл гархийг (гархины голч 2.5 см) дээрх хавтгай хүрэл эдлэлийн нуруунд хавчуулан суран бүсний гадна дотор талаас хавчуулаад бүсний дээр доор 0.8 см зайд 0.3 см голчтой 2 хүрэл хадаасаар хадаж тавлажээ. Хүрэл гархинаас 0.1 см голчтой ойролцоогоор 10 см урт нарийн сурыг 2 давхар гогцоолдон зүүж бэхэлсэн байлаа (Зураг 6-4).

Суран бүстэй хүрэл арал – Хүний зүүн ташаа, бүсэлхий орчмоос илэрсэн. Өргөн талаар нь нугалсан 5.7 см урт, 2.1 см өргөн, 1.5 см зузаан суран бүсний зүүн урд хэсгийн тасархайтай хүрэл арал. 2.4 х 2.1 хэмжээтэй, 0.4 см голчтой хүрэл арлын нуруунд ороож нугалаад 4.5 см урт, 1.9 см өргөн нимгэн хавтгай хүрэл эдлэлийг гадна талаас нь тавьж түүний нэг үзүүрийн 1.7 см өргөн хэмжээтэй дотогш нугалаад суран бүсний үзүүрийг хавчуулжээ. Арлын хүрэл хэл 0.4 см голчтой, 2.1 см урт. Түүнийхээ гадна дотор талаас 4.5 х 1.7 см хэмжээтэй нимгэн гонзгой хүрлээр хавчуулан өөр хоорондоо 1.6 см зайтай зэрэгцүүлэн нүхлээд хүрэл хадаасаар хадаж тавласан байна. Хүрэл аралд бүсний баруун үзүүрийн тасархай хэлэнд гоходжээ. Гохдож үлдсэн суран бүсний тасархай 4.2 см урт. Суран бүс, арал орчимд бөс даавуу тамтархай, төмөр эдлэлийн үлдэгдэл наалдаж барьцалдсан үлдэгдэл мэдэгдэх учир нас барагчийг дээл хувцас

өмсүүлж суран хүрэл тоногтой сураар бүслэн тавьсан хийгээд агсарга бүсэнд төмөр эдлэлүүд байсныг дам харуулна (Зураг 6-4).

Хүрэл чимхүүр – Хүний зүүн хавирга, зүүн ташаа орчмоос илэрсэн. Хүрэл бэлдцийг хэвд цутгаж хийсэн чимхүүр. Нэг үзүүрийг гогцоолдон матаж хавсран урт шилбэ, хурууны үзүүрээр дарах дугуй хэсэг, цүүц хэлбэрт хавтгай хазуур гэсэн 3 хэсгээс бүрдэнэ. Нийт урт 9.3 см, шилбэ хэсгээрээ 0.6 см өргөн, 0.3 см зузаан, хавчин дарах хэсгээр 2.1 см голчтой, 0.2 зузаан бол хазуур талд 1.1 -2 см өргөн, 0.1 см зузаан. Гогцооны голч 0.5 см. Гогцоонд 0.2 см голчтой, 4 см урт суран бүчтэй (Зураг 6-5).

Нумын ясан наалт, гичир – Хүний баруун хавирга орчмоос илэрсэн. Мал юм уу амьтны хавирганы ясыг зорж үйлдсэн наалт 2 ширхэг. Эхний хэсэг 3 хуваагдан хугарсан. 10.9 см урт, 2.2 см өргөн, 0.9 см зузаан. Хоёрдугаар хэсэг 3 хуваагдаж хагарсан. Дотор талыг бүхэлд нь болон гадна талын зарим хэсэгт нарийн хурц үзүүртэй багажаар зурсан явдал наалдуулах чанарыг сайжруулах үүрэгтэй. Хэмжээ 19.1 см урт, 2.5 см өргөн, 0.5 см зузаан. Гичир 12 хэсэг болж хугарч эвдэрсэн хадгалалт муу. Дунджаар 1.4 см өргөн, 0.4 см зузаан байв (Зураг 6-3).

Шавар сав – Савыг модон авс дотор хүний хөлийн улд тулган босгож тавьсан байдалтай олдсон. Бор саарал өнгөтэй бүдүүн ширхэгтэй шаврыг эргэдэг бул ашиглан үйлдсэн дунд зэрэг шатаалттай, амсар орчимд хагарсан болхидуу хийцтэй бүтэн сав. Бага зэрэг цүлхгэр бөөртэй, бүдүүн хүзүү, босоо дэрвэгэр амсартай. Бөөрнөөс дээш шатаж харлан хөө тортог болсон. Нийт 20 см өндөр, бөөрний голч 12 см, зузаан 0.8 см, амсрын голч 10 см, зузаан 0.8 см, хүзүүний голч 8.5 см. Хээгүй, шингэн болон хуурай зүйл хийх зориулалттай (Зураг 6-7).

Төмөр зэвүүд – Хүний баруун гарын бугалга, баруун хавирга орчмоос олдсон. Нийт 5 зэв илэрсэн. Тэдгээрийн хэлбэр хэмжээ ойролцоо, бүгд шилбээрээ хугарсан, хадгалалт муу тул нэгийг төлөөлөн тодорхойлжээ. Гурван мөтөг буюу жигүүртэй, шилбэний угаар хугарч 2 хэсэг болсон. Нийт урт 10.5 см, сурвалжид модны хэсэг наалдаж үлдсэн. 2.7 см өргөн, 0.7 см зузаан (Зураг 6-2).

Төмөр хутганы хугархай – Хүний баруун ташаа, аарцаг орчмоос олдсон. 2 хэсэг болж хугарсан, шөвх үзүүртэй, шулуун мөртэй төмөр хутга. Хутганы бариулд суудаг мод, хүрэл шахуургын үлдэгдэл мэдэгдэнэ. Нийт урт 16 см, үзүүр хэсгээр 1.2, уг 2.8 см өргөн. Зэвэрч муудсан тул өргөнийг тогтоох боломжгүй. Хадгалалт муу (Зураг 6-8).

Хүрэл бөгж – Нас барагчийн зүүн гарын дунд болон ядам хуруунаас олдсон 2 ш хүрэл бөгж. Маш нимгэн хийцтэй, хадгалалт муу учир зөвхөн хурууны ясан дээрх мөр л үлджээ. 1- р бөгж нь

дунд хурууны гуравдугаар үе дээр бий. 0.5 см өргөн. 2-р бөгж ядам хурууны хоёрдугаар үе дээр үлдсэн 0.5 см өргөн.

Бөс, даавууны үлдэгдэл - Нас барагчийн цээжний орчмоос өмхөрч муудсан даавуун дээл хувцасны тамтаг мэдэгдэв. Тэднээс авч ялгахад бор, шар, хар даавууны үлдэгдэл оёдлын оромтой мэдэгдэнэ (Зураг 8).

Арьс ширэн эдлэлийн үлдэгдэл – Хүний баруун ташааны гадна баруун гарын сарвуу орчмоос 15 x 6.2 см хэмжээтэй, нугалж үйлдсэн арьс юм уу ширэн эдлэлийн тасархай. Байрлал, хэлбэр нь хавтагатай төстэй боловч том. Хадгалалт дунд зэрэг. Уг эдлэлийн хамт жижиг хэмжээтэй, нимгэн хүрэл эдлэлийн хугархай хэд хэд олдсон нь чимэглэлийн үлдэгдэл бололтой (Зураг 8).

Зориулалт тодорхойгүй төмөр эдлэл – Хүний зүүн ташааны орчмоос олдсон. Урт зууван хэлбэртэй төмөр эдлэл 2 ширхэг. 1-р эдлэл 16.3 см урт, 1.2 см голчтой. 2-р эдлэл 6 хэсэг хугарсан. Дунджаар 16 см урт, 1.5 см голчтой. Хадгалалт муу. Зэвсгийн төрлийн эдлэл бололтой.

Хэлэлцүүлэг

Өндөр улааны дурсгалын судалгааны дараа зөвхөн булшийг нь лабораторийн он цаггүй урьдчилсан судалгаа маягаар нийтэлснийг дахин дурдах нь зүйтэй. Гэхдээ бид өмнө хэвлэсэн судлаачдын он цагийн баримжааг бататгахын зэрэгцээ үлдсэн хэрэглэгдэхүүнийг бүрэн оруулж тайлбарлахыг хичээв. Өндөр улааны дурсгал нь шавар шороо дэлдэж босгоод гадуур нь хөх өнгийн шавраар өнгөлсөн дөрвөлжин хэлбэртэй, төвдөө өндөр, бага зэрэг ташуу ханатай байгууламж ажээ. Дурсгалаас холгүй орших Талын гурван хэрмийн шороон байгууламжуудтай төстэй боловч хэд хэдэн ялгаа байна. Юуны өмнө Талын гурван хэрэм доторх байгууламжуудыг улаан өнгийн шаврыг зориуд зөөн авчирч үйлдсэн бол Өндөр улааны дурсгалд дэргэдээс нь авсан бор саарал өнгийн элсэрхэг шороо шаврыг ашиглажээ. Талын гурван хэрмийн байгууламжуудын чанх өмнө зүг хандсан дөрвөлжин хэлбэртэй адил байв. Мөн газар сонгох ёс, шавар шороог дагтаршуулсан арга, шон босгоод хашиж овоолдог арга хийгээд, нэг үеийн оруулга булштай зэрэг олон шинжээрээ ижилсдэг.

Түүнчлэн Монгол, Японы хамтарсан Шинэ зуун төслийн хүрээнд Хэний аймгийн Дэлгэрхаан сумын нутагт Гурван дов хэмээх газарт нэг дор 3 шороон дов бүхий дурсгалыг илрүүлэн малтлага судалгаа хийжээ [Б.Цогтбаатар нар, 2016: 52-56; Б.Цогтбаатар нар, 2017: 234-239; Б.Цогтбаатар нар, 2018: 261-264; Б.Цогтбаатар нар, 2019: 219-221]. Судалгааны үр дүнд шороон довуудыг шороо дагтаршуулж үйлдсэн барилгын үлдэгдэл юм уу гэр сууцын үлдэгдэл, магадгүй дэлдсэн өндөр тавцан

дээр гэр, асар барих зориулалттай байсан болов уу хэмээн таамагласан байна. Довуудыг малтан судлах явцад 10 гаруй оруулмал булш илэрсэн нь Сяньби, Түрэг, Хятан, Монголын эзэнт гүрний үед холбогдохыг лабораторийн судалгаагаар тогтоосон байна. Уг шороон довын сууриас авсан дээж НТӨ II зуунд буюу Хүннүгийн үед холбогдох он цаг гарсан бол дурсгалыг орхигдоход дараа үеийн нүүдэлчид тасралтгүй шахам нас барагчдаа оршуулсан байна [白石典之, 2022: 114]. Харин Гурван довын бүтэц, хэлбэрийн талаарх мэдээлэл бүрхэг аж.

Өндөр улааны дурсгал чамгүй өндөр. Гэтэл түүн дээр гардаг нэмэлт зохион байгуулалт байхгүй, хаалга үүд битгий хэл гадуураа хэрэм, усан татаалгүй нь Талын гурван хэрэм болон Тамир голын савд буй хүннүгийн үеийн хот сууринаас эрс ялгарна. Гэтэл малтлагаас илэрсэн цөөн шавар савны хагархайн шатаалт, хийц хэлбэр хүннүгийн үеийн шавар савтай үндсэндээ ижил. Иймээс бид Өндөр улааны шавар шороон байгууламж хүннүгийн үед бүтээгдсэн хэмээн үзэж байна. Харин түүнийг ямар нэгэн шалтгааны улмаас дутуу орхисон. Өөрөөр хэлбэл, гүйцээж чадсангүй хулширсан бололтой.

Харин байгууламж орхигдсон ч түүний онцгой гадаад байдал нь хэдэн зууны дараа буюу жужаны үед оруулмал оршуулга үйлдэх шалтгаан болсон болов уу. Өндөр улааны дурсгалаас илэрсэн булшны он цаг Жужан улсын үед холбогдохыг багтай тогтоож өглөө (347-435 88.6% cal.ce). Жужан улсын үеийн булш монголын өндөрлөгөөс тун цөөн илэрч мэдэгдээд байна. Тэр нь булшны дээр чулуун дараасгүй тавих зан үйл нэгэнт хэвшсэнийг илтгэж болох юм.

Хүннүгийн дараах нүүдэлчдийн булш оршуулгын зан үйлд нэгэн томоохон өөрчлөлт орж эхэлсэн бололтой байдаг. Нийтийн тооллын эхэн үеэр Хүннү болон Хан, Сяньби, Ухуаны холбооны хоорондох тэмцэлд Хүннүгийн хаад ихсийн булш бунхныг тонож зэрэмдэглэсэн тухай мэдээ гардаг. Өвөг дээдсийн шүтээн онгон булшийг тонуулсан тухайн улс аймаг машид доромжлол амсаад зогсохгүй цаашид оршин тогтнох үндэслэлгүй болдог байсан тухай судлаачид тэмдэглэсээр иржээ. Тиймээс Сяньбигаас Монголын эзэнт гүрэн хүртэлх нүүдэлчин овог аймгуудын дунд үхэгсдээ нууцлан, оршуулгын дээр элдэв тэмдэг чулуу тавихгүй хөрсөөр дарах, агуй хадны хөмөгт хүүр биеийг хийж дарах, чандарлах зэрэг зан үйл хүчтэй дэлгэрсэн бололтой. Судлаач С.Хүрэлсүх “хүннүгийн үеэс эхлэн том, жижиг булшийг тонон дээрэмдэж улмаар төр улс мөхөхтэй зэрэгцэн нэгдмэл системтэй байсан оршуулгын зан үйл задарч Сяньби, Жужаны үед оршуулгыг далд нууж тавих зайлшгүй шаардлага үүссэн” хэмээн дүгнэсэн байна (Хүрэлсүх, 2024: 271). Зан үйлийн энэ өвөрмөц улбааг өнөөгийн хадны оршуулгын судалгаа болон

чулуун дараастай булш цөөн олдож буй баримт гэрчилнэ. Өндөр улааны дурсгал, Талын гурван хэрмээс олдсон оршуулга дээрх сэжмийг тайлахад дөхөм үзүүлж болно. Харин хүн бүрийг бус ямар нэгэн ер бусын шалтгаанаар үхэгсдийг эсвэл тухайн хүний гарал, шүтлэгээс хамаарч онцгой тэмдэгтэй газарт оршуулдаг зан үйл үйлчилж байсан юм биш биз? гэсэн сэтгэгдэл төрүүлдэг. Иймд Талын гурван хэрэм, Өндөр улааны булшны эзнийг “язгуурлаг нэгэн эсвэл бөө хүн” (Очир, 2020:183) гэсэн саналыг дэмжиж байна. Түүнчлэн нас барагчид дагуулан тавьсан хойлгын эд зүйл дотор бог малын бүтэн ууц нуруу, сээртэйгээ байгаа нь гойд анхаарал татдаг. Монголын нэрт түүхч Г.Сүхбаатар гуай Жужаныг “нуруу” гэсэн утгатай Нирун хэмээх эртний монгол үг (Сүхбаатар, 1992:164-175) хэмээсэн тайлбарын баримт байж болох юм.

Төгсгөл

Эцэст нь бид Өндөр улааны булшийг шууд жужан булш бус жужаны үеийн булш хэмээн нэрлэх саналтай байна. Учир нь жужаны үеийн булшны материал өнөө хэр хангалтгүй, цаашид шинээр оршуулгын олон дурсгалыг илрүүлэн малтаж лабораторийн хийгээд түүхэн газар зүй, сурвалжийн судалгаанд үндэслэн энэ асуудалд хандах хэрэгтэй.

Өндөр улааны булш, Талын гурван хэрмээс илрүүлсэн булшнууд тонуулчдын гарт өртөөгүй бүрэн бүтэн байдлаар бидний үед ирсэн явдал жужаны үеийн булшны оршуулгын зан үйлийн талаар мэдээллийг баяжуулаад зогсохгүй газар сонгох ёс, оршуулгын зүг чиг, гүн, нас барагчийн биеийг тавих зан үйл, хойлгын эд зүйлийн талаар үнэтэй баримт хангалаа.

Түүнчлэн Орхон Тамирын бэлчир орчимд буй Өндөр улааны дурсгал, Хэрлэн голын савд буй Гурван дов хэмээх дурсгалуудын барьж байгуулсан он цаг ойролцоо, гадаад хэлбэр, үүрэг зориулалтын хувьд ч тун төслөг шинжийг агуулж байна. Өөрөөр хэлбэл, хүннүгийн үед шавар шороо дэлдэж босгосон тахилгын шинжтэй байгууламж хулшран овоолго үлдэхэд сянби, жужаны үеэс түүнийг ямар нэгэн онцгой ариун газар, шүтээний орон хэмээн ойлгож нас барагчаа оршуулж эхэлсэн бололтой. Гэвч сянби, жужаны үед шавар шороо дэлдэж босгосон байгууламж үйлдээд түүн дээрээ нас барагчийг оршуулдаг зан үйл байсныг үгүйсгэхгүй. Нөгөө талаар шороон дов бүхэн бунхант булш хэмээх үзэлд сургамж болж мэднэ. Энэ бүхэн зөвхөн харьцангуй цөөн судлагдаад буй шороон довын үүрэг, зориулалтын талаарх эргэцүүлэл бөгөөд ийм дурсгалыг тууштай хэдийг нэмж малтлага судалгаа хийсний дараа дээрх асуудлуудад хариулах материал цугларах нь дамжиггүй.

Эцэст нь Өндөр улааны дурсгалаас илэрсэн

булшны хүн малын ясанд лабораторийн судалгаа, олдвор хэрэглэгдэхүүний талаарх нарийвчилсан харьцуулсан судалгаа дутагдалтай хэвээр байна..

Талархал

Өндөр улааны булшны он цагийн судалгаанд дэмжлэг үзүүлсэн Доктор Отани Икүэ (Dr. Ikue Otani), Япон улсын Токио их сургуулийн лабораторид гүнээ талархал илэрхийлье.

НОМ ЗҮЙ

Очир, А., Анхбаяр, Б., Цамбагарав, Ж., Цэрэнбямба, Х. Монгол, БНХАУ-ын хамтарсан археологийн малтлага судалгааны 2016 оны монголын талын ажлын тайлан. 2016: 43-59.

Идэрхангай, Т., “Нүүдэлчдийн хаад язгууртны бунхан, тахилгын зан үйл” (Судалгааны ажлын урьдчилсан үр дүнгээс). *Эртний түрэгийн түүх соёл*. ОУЭШХ-ын эмхэтгэл, 2015: 153.

Очир, А., Ёнжи Чэн., Анхбаяр, Б., Цэрэнбямба, Х., Саранбилэг, Фэнфэй Чен, Дандар. “Талын гурван хэрмийн Жужан булш”. *Археологийн судлал*. Tomus XXXV, Fasc. 25, 2015: 380-404.

Jiawei Li, Ye Zhang, Yongbin Zhao, Yongzhi Chen, Ochir, A., Sarenbilige, Hong Zhu, Hui Zhou. “The genome of an ancient Rouran individual reveals an important paternal lineage in the Donghu population”. *American Journal of Physical Anthropology*. Volume 166, Issue 4. 2018: 1-11. <https://doi.org/10.1002/ajpa.23491>

程鹏飞、萨仁毕力格、赵建、巴·昂哈巴雅尔、格·满达哈巴雅尔、贾·参巴嘎拉巴、阿·奥其尔巴特《蒙古国后杭爱省乌贵诺尔苏木温都尔乌兰M1的发掘》《考古》2023年47-52.

Цогтбаатар, Б., Ишцэрэн, Л., Батболд, Г., Амарболд, Э., Ширайши, Н., Миякэ, Т., Сасада, Т. “Монгол-Японы хамтарсан “Шинэ зуун” төслийн 2016 оны хээрийн шинжилгээний ажлын товч үр дүн”. *Монголын археологи 2016. Хурлын эмхэтгэл*, 2016: 52-56.

Цогтбаатар, Б., Ширайши, Н., Миякэ, Т., Ишцэрэн, Л., Батболд, Г., Амгалантөгс, Ц. “Монгол-Японы хамтарсан шинэ зуун төслийн 2017 оны малтлага судалгааны товч үр дүнгээс”. *Монголын археологи 2017. Хурлын эмхэтгэл*, 2017: 234-239.

Цогтбаатар, Б., Ширайши, Н., Миякэ, Т., Амарболд, Э., Батболд, Г. “Гурван дов хэмээх дурсгалд явуулсан археологийн судалгааны урьдчилсан үр дүн”. *Монголын археологи 2018. Хурлын эмхэтгэл*, 2018: 261-264.

Цогтбаатар, Б., Ширайши, Н., Миякэ, Т., Ишцэрэн, Л., Батболд, Г., Амарболд, Э., Бүрэнтөгс, Л., Маргад-эрдэнэ, Г. “Монгол-Японы хамтарсан Шинэ зуун төслийн 2019 оны хээрийн судалгааны урьдчилсан үр дүнгээс”. *Монголын археологи 2019. Хурлын эмхэтгэл*, 2019: 219-221.

白石典之《モンゴル考古学概説》2022年 113-115頁.

Очир, А. “Жужан булш, түүний оршуулгын ёсны уламжлал”. *Археологийн судалгаа: Монголчуудын гарал түүний угсаа-соёлын хөгжил*. 2020: 183.

Хүрэлсүх, С. *Хадны оршуулга: Монголчуудын эртний оршуулгын өвөрмөц хэлбэр*. 2024: 271.

Сүхбаатар, Г. *Монгол Нурун улс (330-555)*. 1992: 164-175.

REFERENCES

Ochir A., Ankhubayar, B., Tsambagarav, J., Tserenbyamba, H. Mongol, Hyatadyn hamtarsan arheologyn maltlaga sudalgaany 2016 onii mongolyn talyn ajlyn tailan. Nuudliin soyol irgenshliig sudlah olon ulsyn hureelengiin Gar bichmeliin san humrug, 2016: 43-59.

Iderhangai, T. “Nuudelchdiin haad yazguurty bunhan, tahlilgyn zan uil (Sudalgaany ajlyn uridchilsan ur dungees)”. *Ertanii turegiin tuuh soyol*. Olon ulsyn erdem shinjilgeenii hurlyn emhetgel, 2015: 153.

Ochir, A., Yongzhi Chen, Ankhubayar, B., Tserenbyamba, H., Saranbileg, Pengfei Chen, Dandar. “Talyn gurban hermiin Jujan bulsh”. *Studia Archaeologica*. Tomus XXXV, Fasc. 25, 2015: 380-404.

Jiawei Li, Ye Zhang, Yongbin Zhao, Yongzhi Chen, Ochir, A., Sarenbilige, Hong Zhu, Hui Zhou. “The genome of an ancient Rouran individual reveals an important paternal lineage in the Donghu population”. *American Journal of Physical Anthropology*. Volume 166, Issue 4. 2018: 1-11. <https://doi.org/10.1002/ajpa.23491>

程鹏飞、萨仁毕力格、赵建, 巴·昂哈巴雅尔、格·满达哈巴雅尔、贾·参巴嘎拉巴、阿·奥其尔巴特 《蒙古国后杭爱省乌贵诺尔苏木温都尔乌兰M1的发掘》《考古》2023年47-52页.

Tsogtbaatar, B., Ishtseren, L., Batbold, G., Amarbold, E., Shiraishi, N., Miyake, T., Sasada, T.

“Mongol, Yo pony hamtarsan Shine Zuun tusliin 2016 ony heeriin shinjilgeenii ajlyn tovch ur dun”. *Mongolyn arheologi 2016*. 2016: 52-56.

Tsogtbaatar, B., Shiraishi, N., Miyake, T., Ishtseren, L., Batbold, G., Amgalantugs, Ts. “Mongol, Yo pony hamtarsan Shine Zuun tusliin 2017 ony maltlaga sudalgaany tovch ur dungees”. *Mongolyn arheologi 2017*. 2017: 234-239.

Tsogtbaatar, B., Shiraishi, N., Miyake, T., Amarbold, E., Batbold, G. “Gurban Dov hemeeh dursgald yavuulsan arheologyn sudalgaany uridchilsan ur dun”. *Mongolyn arheologi 2018*. 2018: 261-264.

Tsogtbaatar, B., Shiraishi, N., Miyake, T., Ishtseren, L., Batbold, G., Amarbold, E., Burentugs, L., Margaderdene, G. “Mongol, Yo pony hamtarsan Shine Zuun tusliin 2019 ony heeriin shinjilgeenii ajlyn tovch ur dungees”. *Mongolyn arheologi 2019*. 2019: 219-221.

白石典之《モンゴル考古学概説》2022年 113-115頁

Ochir, A. “Jujan bulsh, tuunii orshuulgyn yosny ulamjilal”. *Arheologyn sudalгаа: Mongolchuudyn garal tuunii ugsaa-soyolyn hugjul*. 2020: 183.

Khurelsuh, S. *Khadny orshuulga: Mongolchuudyn ertii orshuulgyn uvurmuts helber*. 2024: 271.


Sukhbaatar, G. *Mongol Nirun uls (330-555)*. 1992: 164-175.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>


Хавсралт зураг




Зураг 1. Өндөр улааны дурсгалын байршил




Зураг 2. Өндөр улааны дурсгалын гэрэл зураг (Өмнө талаас)




Зураг 3. Өндөр улааны дурсгалын малтлагын явцын гар зураглал



Зураг 4. Оршуулгын гар зураг (M1)



Зураг 5. Булинд хийсэн лабораторийн дээжийн хариу (дугаар: ТКА-27555)



Зураг 6. 1-хүрэл зүүлт, 2-төмөр зэвүүд, 3-нумын ясан наалт, 4-суран бүстэй агсарга бүсний үлдэгдэл, 5-хүрэл чимхүүр, 6-гал асаагуур, 7-шавар сав, төмөр хутга (程鹏飞, 2023)



Зураг 7. Оршуулгын гэрэл зураг



Хүрэл чимэгтэй суран агсарга бүсний үлдэгдэл



Хүрэл аралтай, агсарга суран бүсний үлдэгдэл



Хүрэл чимхүүр



Нумын ясан наалтууд



Модон гал асаагуур



Хүрэл зүүлт



Шавар сав



Бөс даавууны үлдэгдэл



Арьс, ширэн эдлэл



Бог малын ууц, нурууны яс



Төмөр зэвүүд

Зураг 8. Олдворын гэрэл зургууд



Зураг 9. Шороон довыг дэлдсэн байдал (Сорилын малтлага)



Зураг 10. Шонгийн нүхнүүд (D1,D2)



Зураг 11. Шороон довын ханаас урссан хөх шавар (талбайн малтлага)